

БАТЛАВ. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.ТӨМӨРХҮҮ

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2014 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	ХИЙХ АЖИЛ	Хугацаа	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	Шалгуур үзүүлэлт
-----	-----------	---------	------------------------------	---------------------

НЭГ. Авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох

1	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг төлөвлөж батлуулах	3 сард	Төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байх, эрх зүйн актуудыг нэгдсэн програмд оруулах, мэдээлэл авах нөхцлийг хангах техник хэрэгслэлтэй болсон байх	
2	Гүйцэтгэх захирлын тушаал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллах	жилийн турш	Мэдээллийн самбар, цахим хуудас, албан тоотоор нэгжүүдэд хүргэж мэдээлэх	
3	Дэд захирал, хэлтэс, албаны дарга, төвийн менежертэй байгуулах хөдөлмөрийн гэрээний загварыг шинэчлэх, гэрээнд авлигатай холбоотой зөрчил гаргахгүй байх заалт оруулж мөрдүүлэх	3 дугаар сард	Гэрээ байгуулсан байх	
4	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах талаар Авлигатай тэмцэх газраас мэргэжлийн ажилтан урьж хичээл заалгах	11 дүгээр сард	Хичээл заалгаж ажилтнууд өөрсдөө мэдүүлгээ цахим хэлбэрээр гаргах чадвартай болох	
5	Компанийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүдийг олон нийтэд ил тод газарт байрлуулах ажлыг зохион байгуулах	4 сард	Тусгай зөвшөөрлүүдийг байрлуулах ажлыг нэгж бүр дээр зохион байгуулах	
6	Компанийн харьяа нэгжүүдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон гэнэтийн үзлэг шалгалтыг жилийн турш явуулж мөрөөр нь тодорхой ажил зохиох, сэрэмжлүүлэх мэдээ, мэдээлэл хүргэж хэрэгжүүлэх	жилийн турш	Шалгалтын мөрөөр хийх ажлын төлөвлөгөө, сэрэмжлүүлэх албан даалгавар гаргаж хэрэгжүүлэх	

7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж тендерийн урилгыг цахим хуудас болон хэвлэлд тухай бүр гаргах, олон нийтийг мэдээлэл авах эрхээр хангах, шаардлагатай мэдээллийг зохих журмын дагуу өгч байх	жилдээ	Мэдээлсэн байх	
---	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------	----------------	--

ХОЁР. Албан хаагчийн шударга байдлыг хангах

8	Компанийн удирдлага, удирдах ажилтнуудын талаар ажилтнуудын дунд санал асуулгын хуудсаар санал авах	2 сард	харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төв, түгээх төвийн ажилтнуудын дунд тэдгээрийн удирдлагын талаар хуудсаар санал асуулга явуулж дүгнэсэн байх	
9	Авлигатай холбоотой гарсан зөрчил, хариуцлага тооцсон талаар тухай бүр мэдээлж сэрэмжлүүлэх, холбогдох нэгжид албан даалгавар, шаардлага өгч биелэлтийг тооцох	жилийн турш	Тухайн үед мөрдөх	
10	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй харилцах боломжоор хангах	жилийн турш	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байх	
11	Байгууллагын хүний нөөцийн стратегийг боловсруулж батлуулах	3-р улиралд	Стратегийг гаргасан байх	
12	Компанийн ажилтны ёс зүйн дүрмийг шинэчлэн мөрдүүлэх	4 сард	Тушаалаар батлуулж мөрдүүлэх	
13	Ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн мөрдүүлэх	1-3 сард	Тушаалаар батлуулж нэгжүүдэд хүргүүлсэн байх	
14	Компаниас гадагш гаргадаг зөвшөөрөлд гарын үсэг зурдаг эрх бүхий албан тушаалын болон авлигад өртөж болзошгүй албан тушаалын судалгаа гаргаж хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалыг шинэчлэн зарим өөрчлөлт оруулах	3 сард	Албан тоот боловсруулж хүргүүлэх	

асуудлыг Авлигатай тэмцэх газарт тавьж шийдвэрлүүлэх			
------------------------------------------------------	--	--	--

ГУРАВ. Тогтолцооны шударга байдлыг хангах

15	Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй дэг жаяг, журам, заавар, дүрмийн хэрэгжилтэд байнгын хяналт тавих, үзлэг шалгалт хийх	жилийн турш		-Шалгалтаар илэрсэн зөрчил арилсан, хариуцлага тооцсон байх
16	Хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг цахим хэлбэрээр байгуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх	2-р улиралд	Цахим хэлбэрээр гэрээ байгуулах арга замыг судлах, хууль, шүүхийн байгууллагаас тодруулах, гэрээ байгуулах журам боловсруулах зэрэг бэлтгэл ажлыг хангасан байх	
17	Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэх шат дэмжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	жилдээ		
18	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтны зарим шийдвэрийг цахим хуудсанд байршуулсан байх	жилдээ	Цахим хуудсанд байршуулсан байх	
19	Хэрэглэгчдэд үзүүлдэг үйлчилгээний төлбөр хураамжийн мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах	жилдээ		
20	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	4 сард	Жилийн эцсийн санхүүгийн тайлан, тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл,	

			хөтөлбөрийн хэрэгжилтийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан байх	
21	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	жилдээ	Шийдвэрийг биелүүлэх ажил зохиох	

ДӨРӨВ. Хяналтын үйл ажиллагаа


22	Ажилтнуудын ажлаа тайлагнах тогтолцоог сайжруулах, жилийн эцэст бүх ажилтнуудын хийсэн ажлыг дүгнэж хариуцлага тооцох	жилийн эцэст	Компанийн хэмжээнд оны эцэст хүн бүр тайлан гаргаж түүнийгээ хамгаална.	
23	Шалгалтаар илэрсэн ноцтой зөрчлүүдийг хуулийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх	тухай бүр		
24	Сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил зохиох	<u>жтурш</u>		

Төлөвлөгөө гаргасан хуулийн зөвлөх



Н.Цэндсүрэн

ТАНИЛЦСАН ЗХНХ-ИЙН ДАРГА



Т.БАТЦЭЦЭГ

ЗӨВЛӨМЖ

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь үялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих” чиг үүргийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авч ирсэн юм.

Энэ арга хэмжээний хүрээнд 2013 онд 122 төрийн байгууллагын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг анх удаа улсын хэмжээнд хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлсэнээс 48 төрийн өмчит аж ахуйн нэгж хамрагдсан юм.

Хуулинд заасан үндэслэл, журмын дагуу сонгон шалгаруулсан хөндлөнгийн “Шинжээчдийн баг” тухайн байгууллагын цахим хуудсанд тавьсан мэдээлэл болон авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан, үйл ажиллагааг нотлох баримтын хэмжээнд хийж үр дүнг нийтэд мэдээлсэн бөгөөд цаашид жил бүр үнэлгээ хийгдэх болсонтой холбогдуулан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагуудад авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад дараахь зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд;

1/ авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг төлөвлөн, санхүүжүүлэх;

2/ авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах;

3/ компаний удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах /хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол захирлын тушаал, дүрэмд орсон өөрчлөлт г.м/;

4/ аж ахуйн нэгж нь аливаа үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа тохиолдолд түүнтэй холбоотой мэдээллийг ил тод болгож, олон нийтэд танилцах боломжоор хангах;

5/ компаний төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий инженер, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нябо, инженерийн албаны дарга, захиргаа удирдлагын хэтсийн дарга, хангамжийн хэлтсийн дарга, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга гэх мэт албан тушаалтны танилцуулга болон холбогдох хуулиар хориглоогүй мэдээллийг ил тод болгох;

6/ төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалт, компаний дүрэмд тусгасан “ хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэсэн бизнесийн бусад үйл ажиллагаа” эрхэлсэн талаарх мэдээлэл, ногдол ашгийн хуваарилалт, түүнийг хэрхэн олгох талаарх мэдээллийг олон нийтэд тухай бүр мэдээлэх;

7/ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах;

8/ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах;

9/ чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах;

10/ аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх зэрэг компаний тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо, өмчлөгчийн хяналт, дотоод хяналт, хөндлөнгийн аудит зэрэгхяналтын тогтолцооны бүтцийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгох;

11/ албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох;

12/ авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах, хамтран ажиллах;

13/ авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх ;

14/ ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх;

13/ давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх ;

15/ байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах;

16/ иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах;

17/ авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах;

18 /авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх;

19/ авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх зэрэг болно.

Та бүхэн 2014 онд “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-д тусгасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч, хамтран ажиллана уу.

**2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хийх ажлын агуулга, эрх зүйн үндэслэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан	Бусад тайлбар
1	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэм-жээг боловсруулж хэрэгжүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2;</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлтийн байдал</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлагналт</p>	<p>3/15</p> <p>3/15-11/15</p> <p>11/15</p>	<p>Хуулийн хэлтэс, алба, Байгууллагын эрх бүхий албан тушаалтан</p>	<p>Хүрсэн үр дүн</p>

		Төлөвлөсөн арга хэмжээг хэ-рэгжүүлэх зардлыг тусгай-лан төлөвлөж, санхүүжүүлсэн байдал	03/15		
--	--	-------------------------------------------------------------------------------------------------	-------	--	--